

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны
А/401 дугаар сарын 12-ны өдрийн 27
дугаар тушаалын хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл:

- ☒ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан
шинэчлэн боловсруулсан
- ☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2023.12.27 А/401

Байгууллагын нэр:

Экологийн цагдаагийн алба

Нэгжийн нэр:

Дүн шинжилгээ, хяналт шалгалтын хэлтэс

Албан тушаалын нэр:

Мэдээлэл судалгааны ахлах
мэргэжилтэн

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТТ-5

Ажлын цаг:

8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Сүхбаатар дүүрэг, 7 дүгээр хороо, Эрхүүгийн
гудамж-6

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Байгалийн гамшиг, гал түймэр, хүн, малын гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн болон бусад аюул тохиолдсон, нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага, онц болон дайны байдал зарласан, онц ноцтой гэмт хэрэг үйлдэгдсэн зэрэг зайлшгүй тохиолдолд уртасгасан цагаар болон өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах.

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ:

Албан тушаалын зорилго:

Монгол Улсын Үндсэн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан хууль тогтоомж болон Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг хэрэгжүүлэхэд хяналт тавьж удирдлагыг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх.

Албан тушаалын зорилт:

- “Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөх”, “Зөрчлийн тоо бүртгэл хөтлөх” журмуудын хэрэгжилтийг хангаж, тухайн нутаг дэвсгэрт бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчил, гомдол мэдээллийн болон холбогдох бусад мэдээллийн сан бүрдүүлж, хөдөлгөөнд хяналт тавих.
- Гэмт хэрэг, зөрчлийн болон холбогдох бусад мэдээллийн сангаас судалгаа, танилцуулга бэлтгэх, эрх бүхий байгууллага, албан тушаалтныг мэдээллээр хангах.
- Эрх бүхий байгууллага, албан тушаалтны хүсэлтээр иргэн, хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх талаар лавлагаа олгох.

4.Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн албан тушаалын зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах –Т, Харилцан, гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.1.Эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас батлан гаргасан анхан шатны бүртгэлийн маягтын дагуу гэмт хэрэг, зөрчил, гомдол, мэдээллийн санг төрөлжүүлэн бүрдүүлэх, баяжилт, хөдөлгөөнд хяналт тавих; 1.2.Дээд шатны байгууллага, албан тушаалтнаас мэдээллийн сангийн талаар өгсөн үүрэг, ажлын чиглэлийг тогтоосон хугацаанд нь хэрэгжүүлж, үр дүнг танилцуулах;	Эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрийн үндэслэл оновчтой болж, байгууллагын үйл ажиллагааг зөвлөмжөөр дэмжих нөхцөл бүрдэнэ.	Г Г
2 дугаар зорилтын хүрээнд	2.1.Статистик, мэдээллийн хэлтсээс /сар бүр өсгөн нэмэгдүүлсэн дүнгээр/ гарган хүргүүлсэн статистик мэдээнд тулгуурлан хариуцсан нутаг дэвсгэрийн эрүү болон хэв журмын нөхцөл байдлын талаарх судалгаа, мэдээлэл бэлтгэж байгууллагын удирдлага, алба хаагчдад танилцуулах; 2.2.Хариуцсан нутаг дэвсгэрийн эрүү болон хэв журмын нөхцөл байдал, бүртгэгдсэн гомдол мэдээлэл, түүний шийдвэрлэлийн талаар 7 хоног бүр, алба хаагчдын мэдээллийн санд ажилласан байдлын талаар сар бүр мэдээлэл, танилцуулга бэлтгэн нэгжийн удирдлага, алба хаагчдыг мэдээллээр хангах; 2.3.Эрх бүхий албан тушаалтнаас ирүүлсэн хүсэлтийн дагуу мэдээллийн сангаас шаардлагатай судалгаа, мэдээлэл гарган хүргүүлэх, бүртгэл хөтлөх.	Гэмт хэрэгтэй тэмцэх арга зам боловсронгуй болж, нэгжүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоо хангагдана.	Г Г
3 дугаар зорилтын хүрээнд	3.1.Эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн эрх зүйн үндэслэл бүхий албан бичгийн дагуу иргэн, хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэхийг мэдээллийн сангаас шалган лавлагаа өгөх. 3.2.Албан үүрэг гүйцэтгэх явцад мэдсэн гомдол мэдээлэл, эрүүгийн хэрэг, иргэн байгууллагын нууцлал болон мэдээллийн аюулгүй байдал, нууцлалыг хангах	Мэдээллийн үнэн бодит шуурхай байдал хангагдаж, нэгдсэн мэдээллээр хангагдах нөхцөл бүрдэнэ.	Г Г
4 дүгээр зорилтын хүрээнд	4.1.Харьяалах нэгжийн алба хаагчдаас гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөх, мэдээллийн сан бүрдүүлж буй ажлыг шалган, зааварчлах, үр дүнг тооцох. 4.2.Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм	Хуулиар хүлээлгэсэн нийтлэг чиг үүргийн	Г Г

хэмжээг сахин биелүүлж, байгууллагын ажилтнууд болон харилцагч, үйлчлүүлэгчид, иргэдтэй зөв боловсон харьцах, ёс зүйн зөрчил, дутагдал гаргахгүй байх;	биелэлт хангагдана	
4.3.Авлига, хүнд суртлаас ангид байж, хүний эрх,эрх чөлөөг хүндэтгэн.шударга ёсыг эрхэмлэн," Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг чанд мөрдөх;		Г
4.4.Явцуу эрх ашиг сонирхлоос татгалзаж, цагдаагийн байгууллага, албаны нийтлэг эрх ашиг сонирхлыг эрхэмлэн ажиллах.		Г

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА


Боловсрол	Дээд боловсролтой, Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.	
Мэргэжил	-Эрх зүй /0421/ -Статистик /0542/ -Иргэн, өмч хөрөнгө хамгаалал /1032/	
Мэргэшил	Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх.	
Туршлага	Цагдаагийн байгууллагад 6-аас доошгүй жил, үүнээс нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын офицер албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх.	
	Дүн шинжилгээ хийх	-Мэдээлэлийн үнэн, бодит байдлыг шалган нягтлах, -Нарийн төвөгтэй мэдээллийг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тодруулах, -Байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх, -Судалгааны арга зүйн мэдлэгтэй
	Асуудал шийдвэрлэх	-Өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах; -Асуудал шийдвэрлэх эдийн засаг, хууль зүйн үндэслэлийг тодорхойлох; -Удирдлагын өгсөн чиглэлийн дагуу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээг зохион байгуулах.
	Манлайлах	-Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; -Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох.
	Бусад	-Албан хэрэг хөтлөлт боловсруулах, монгол хэл, бичгийн дүрэм, үг зүй, найруулга зүйн зохих мэдлэгтэй байх. -Компьютерийн Microsoft Office Word, Microsoft Office Excel, Microsoft Office Power Point программуудыг хэрэглээний түвшинд ашиглах чадвартай байх. -Нууц хадгалах.

IV. АЛБАН ТУШААЛЫН ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: Дэд бөгөөд Дүн шинжилгээ, хяналт шалгалтын хэлтсийн дарга	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект: Шууд харилцах байгууллага: -Хариуцсан асуудлаар бусад яам, агентлагийн албан тушаалын адил болон түүнээс доош зэрэглэлтэй албан тушаалтан;

	Шууд бус харилцах байгууллага: -Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хуулийн этгээд, иргэн; /Эдгээртэй харилцахдаа Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж, үйл ажиллагааны журмын холбогдох заалтыг баримтална/.
--	---

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ:

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА  Т.ГАНЗОРИГ 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдөр	Байгууллагын нэр: Шийдвэрийн огноо: Дугаар:.....

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:	
Байгууллагын нэр: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР Шийдвэрийн огноо: 2023 оны 12 дугаар сарын 27 өдөр Дугаар: А/401 ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА  Т.СҮХБОЛД 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр	

ТАНИЛЦСАН:

Албан тушаалтан:
.....
.....
20...оны дугаар сарын-ны өдөр